



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 4/26

Улаанбаатар хот

Хүүхэд хүлээн авах
журам батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 16.13, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 13.3.1 дахь заалт, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 12 сарын 31-ны өдрийн А/213 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сэргээн засах төвд хүүхэд хүлээн авах журам"-ыг нэгдүгээр, "Сэргээн засах төвд эмчлэх, сувилах, сэргээн засах, чийрэгжүүлэх үндсэн чиглэл"-ыг хоёрдугаар, "Үйлчлүүлэгч хүлээж авахгүй заалт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөн ажиллахыг эмчилгээний тасгийн эрхлэгчид үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанарын аюулгүй байдлын багийн ахлагчид даалгасугай.

ДАРГА *Ш.САРУУЛТУЯА* Ш.САРУУЛТУЯА
9020010253 9123733

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн даргын 2021 оны 10.3.. сарын 21.....өдрийн
дугаар тушаалтын хавсралт

A/26

60200100534 8123713

ХҮҮХЭД ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ ШИНЭЧИЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, сэргээн засахтай холбоотой эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүн амд сэргээн засахын тусlamж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэхэд журмын зорилго оршино.
- 1.2 Сэргээн засах төвийн үйлчлүүлэгчдийг эмчилж сувилах, чийрэгжүүлэх сэргээн засахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Хүүхэд хүлээж авах зарчим

- 2.1. Сэргээн засах төвийн тусlamж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, үйлчлүүлэгчийн хүлээн авах зорилгоор "13A" маягтыг хэрэглэнэ.
- 2.2. Дүүргийн эрүүл мэндийн төвүүд, Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь үйлчлүүлэгч илгээхдээ "Сэргээн засах төвд эмчлэх, сувилах, сэргээн засах чийрэгжүүлэх өвчний жагсаалт"-ын заалтыг баримтална.
- 2.3. Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр (амбулаторийн карт)-д үндсэн онош бодит үзлэг, өвчний эмнэлзүйн шинж хийгдсэн эмчилгээ, дагалдах өвчин зэргийг тодорхой бичиж тэмдэглэх ба шаардлагатай лабораторийн болон багажийн шинжилгээний хариуг хавсаргана. Үүнд:
 - Цусны ерөнхий шинжилгээ
 - Шээсний ерөнхий шинжилгээ
 - Цагаан хорхойн шинжилгээ
 - Шээсэнд ЖПЖ үзүүлэх
 - 13A маягтыг үнэн зөв шинжилгээг үндэслэн бичсэн байх
 - Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр (амбулаторийн карт)
 - Төрсний гэрчилгээний хуулбар
 - Дархлаажуулалтын картны хуулбар
 - Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчийн иргэний үнэмлэхний хуулбар
 - Шаардлагатай тохиолдолд онош тодруулахаар хийгдсэн нэмэлт шинжилгээ зэргийг хавсаргана.
 - Хувийн бэлтгэл: / Биед эвтэйхэйн нимгэн хувцас, гадуур хувцас хийх том уут, сольж өмсөх 1-2 ээлжийн хувцас хийх жижиг уут, хүүхдийн oo сойз, чийг татдаггүй хөнгөн гутал г.м/ Ахуйн хэрэгцээнд:

- о 00-н цаас 4ш
- о Seficard бактерийн эсрэг гарын шингэн саван 3ш
- о Тор барааны саван 4 ш
- о Хатуу гар нүүрийн саван 1ш
- о Сальфетик хуурай том хайрцагтай 3ш

Гурав. Сэргээн засах төвийн эмчилгээ, сувилгаа, чийрэгжүүлэлт

- 3.1. Сэргээн засах төвийн дүрмээр хүлээсэн үүргийн дагуу тусlamж, үйлчилгээ үзүүлнэ.
- 3.2. Тусlamж, үйлчилгээнд ЭМС-ын 2019 оны Журам шинэчлэн батлах тухай /Сэргээн засах тусlamж, үйлчилгээ үзүүлэх журам/ A/502 тоот тушаал, ЭМС -ын 2017 оны "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс, бодисын зөвлөмж хэмжээ" A/74 дүгээр тушаал, Сэргээн засах төвийн даргын 2021 оны 03 сарын 25- ны өдрийн A/20 тоот тушаал "Яаралтай тусlamжийн нэгжийн ажиллах журам", "Эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлүүд MNS4621:2008", 2020 оны шинэчлэгдсэн Хүүхдийн өвчний цогц менежмент болон бусад холбогдох баримт бичгийг мөрдөнө.

Дөрөв. Үйлчлүүлэгч гаргах, эмчилгээг зогсоох

- 4.1 Журамд заасан хориглох өвчний оноштой
- 4.2 Сэргээн засах төвийн дотоод журам зөрчиж шалтгаангүйгээр 5 дээш хоног ирэхгүй байх.
- 4.3 Үйлчлүүлэгчийг хүлээн аваагүй, буцаасан тохиолдолд шалтгаан мэдээллийг тусгай бүртгэлд бүртгэн мэдээллийн санг бүрдүүлсэн байна.
- 4.4 Оношилгоо, шинжилгээ дутуу
- 4.5 Бичиг баримт дутуу
- 4.6 Эцэг эх нь хүсэлт гаргасан
- 4.7 Хүүхдийн биеийн байдал сайжирсан
- 4.8 Насанд тохирсон жин өндрийн харьцаа хэвийн болсон
- 4.9 Цусны шинжилгээний үзүүлэлт хэвийн болсон
- 4.10 Хүүхэд бие даах чадвар сайжирсан

Тав. Бусад

- 5.1. Энэ журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтан, байгууллагад Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл урс төвийн
даргын 2021 оны 03 сарын 31...өдрийн
126 дугаар тушаалын 2 хавсралт

Сэргээн засах төвд эмчлэх, сувилах, сэргээн засах

Чийрэгжүүлэх үндсэн чиглэл

№	Өвчний нэр	Сэргээн засах төвд эмчлэх өвчний үе шат, онцлог
1	Цус багадалт	<ul style="list-style-type: none"> Эмнэлзүй: Алга цайсан (ХӨЦМ-өөр) Цусны дэлгэрэнгүй шилжилгээ: <ul style="list-style-type: none"> 1 хүртлэх нас: <ul style="list-style-type: none"> - Hb < 100 (g/l) - MCV < 70 (fl) - MCH < 23 (pg) 1 дээш нас: <ul style="list-style-type: none"> - Hb < 110 (g/l) - MCV < 72 (fl) - MCH < 24 (pg)
2	Рахит	<ul style="list-style-type: none"> Эмнэлзүй (ХӨЦМ-өөр) <ul style="list-style-type: none"> - Уух буюу хөхөө хөхөхдөө хөлрөх - Шээс үнэртэй болох - Гавлын яс зөөлрөх - "Сампингийн эрх"-ийн шинж - Булчингийн хүчдэл сулрах эдгээр шинжээс хоёроос дээш шинж илэрсэн Шинжилгээнд <ul style="list-style-type: none"> - 25 OH vitamin D < 30 nmol/l, - Ca < 2.1 mmol/l, - P < 1.3 mmol/l
3	Хоол тэжээлийн цочмог дутагдал (ХӨЦМ)	<ul style="list-style-type: none"> Ж/Ө/Ү < (-2) 6 сараас дээш насны хүүхдэд бугалганы тойргийн хэмжээ < 125 мм, Чулицкийн индекс < 15 2 хөлд хавантай
4	Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд авна (ДЦП хөнгөн зэргийн гидроцефалия гэх мэт)	<ul style="list-style-type: none"> Нийлмэл хөдөлгөөний үйл ажиллагааг ангилах систем (GMFCS) –ээр I- III гэж үнэлэгдсэн хүүхэд <ul style="list-style-type: none"> - GMFCS I: Бүх гадаргуу дээр бие даан алхаж, гүйж, үсрэх боловч хурд, тэнцвэр, зохицуулалт алдагдсан. Хөдөлгөөний шилжилтийг бие даан хийх боломжтой, жишээлбэл гар ашиглахгүйгээр сандал дээрээс босох боломжтой - GMFCS II: Алхаж сурч байхдаа алхах хүрээ гэх мэт хөдөлгөөнт туслах төхөөрөмж хэрэгтэй. 6-тай бол тэд бие даан алхах боломжтой боловч тэгш бус гадаргуу, налуу дээр алхах, хүн цугласан эсвэл хязгаарлагдмал орон зайд алхаж

		<p>чадахгүй. Шатны төмрөөс бариад шатаар авирдаг. Гүйх, үсрэх хязгаарлагдмал чадвартай (хамгийн сайн нь)</p> <ul style="list-style-type: none"> - GMFCS III: Явахад туслах хөдөлгөөнт төхөөрөмж буюу ортопед хэрэгтэй. Хол зайнд, нийгмийн харилцаанд ороход тэргэнцэртэй явах. Өөрөө өөрөө явагч тэргэнцэртэй байж болох боловч илүү хол зайд эсвэл тэгш бус гадаргуу дээр түлхэх шаардлагатай. Бие даан сууна. Шалан дээр биеэ даан хөдөлнө • Чадвараар ангилах систем (MACS)- ээр I-IV гэж үнэлэгдсэн хүүхэд <ul style="list-style-type: none"> - MACS I: Объектийг гараараа хялбар барьж чадна. Хурд, нямбай байдал шаарддаг үйлийг гүйцэтгэхэд зарим бэрхшээл тулгардаг. Өдөр тутмын үйл ажиллагаандаа биеэ даасан байх - MACS II: Ихэнх объектийг гараар хийх чанар ба хурд буурсан. Гүйцэтгэлийн альтернатив арга замаар гүйцэтгэдэг. Өдөр тутмын амьдралын ихэнх идэвхитэй үйл ажиллагаа хязгаарлагдаагүй - MACS III: Объектийг гараар хийх нь бэрхшээлтэй. Гүйцэтгэл нь удаан ба хязгаарлагдмал байдалтай. Бэлтгэх / өөрчлөхд тусламж хэрэгтэй • Хөгжлийн үндсэн 4 хүрээ наснаасаа 2-3 сараар хоцорсон. <ul style="list-style-type: none"> - Нийлмэл хөдөлгөөн – толгойгоо даах, суух, өнхрөх, мөлхөх, алхах, гүйх, үсрэх, харайх, дээс тоглох, дугуй унах ба бөмбөгөөр тоглох - Нарийн нийлмэл хөдөлгөөн – анхаарал хандуудах, эд зүйлийг барих (харандаа, хайч), өрдөг тоглоом, шүр хэлхэх, эвлүүлдэг тоглоом тоглох ба асуудлыг шийдвэрлэх - Хэл яриа – Дуу чимээнд хариулах, ганганах, шулганах, ганц нэг үгээр ярих, зааврыг ойлгох (дагаж мөрдөхгүй) (1 -ээс 2-3), нийлмэл өгүүлбэрээр ярих, хийсвэр ойлголт - Нийгэмшил - (өөрийгөө арчлах ба нийгэмших чадвар) - хооллох, хувцаслах, халамжлах, гэр бүл ба танихгүй хүнтэй харилцах, тоглох (ганцаараа, тус тусдаа, хамтарч)
5	Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> • Амьсгалын замын халдварт өртөмтийжилдээ 3-4 удаа эмнэлэгт хэвтсэн • Амьсгалын замын эмгэгээр удаан хугацаанд эмнэлэгт хэвтэж эмчлэгдэж гарсны дараах сэргээн засах эмчилгээ
6	Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> • Хоол боловсруулах замын халдвартын бус өвчинеэр эмчлүүлсний дараах байдал • Элэгний хурц үрэвслээр өвчилж эмчлүүлсний дараах байдал
7	Бөөр шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> • Шээс задгайрах
8	Бусад	<ul style="list-style-type: none"> • Шүүдэст эмзэгшлийн намжилтын үе

Үйлчлүүлэгч хүлээж авахгүй заалт

№	Өвчний нэр	Өвчний үе шат, онцлог
1	Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> ● Амьсгалын замын цочмог халдварууд ● Гуурсан хоолойн багтрааны сэдрэлийн үе ● Сүрьеэз
2	Зүрх судасны эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> ● Зүрх, судасны дутмагшилтай ● Зүрхний төрөлхийн хавсарсан хүнд гажигтай ●
3	Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> ● Хоол боловсруулах замын цочмог эмгэг ● Халдварын гаралтай хоол боловсруулах замын цочмог эмгэг ●
4	Бөөр шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> ● Бөөр шээсний замын цочмог халдвартай ● Бөөр шээсний замын чулуу
5	Мэдрэлийн эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> ● Тархины саажилт хүнд хэлбэр ● Уналт таталтын хүнд хэлбэр
6	Бусад	<ul style="list-style-type: none"> ● Арьс харшлын хурц хэлбэрүүд ● З дээш настай хүүхэд ● Өмнөх улиралд сэргээн засах төвд хамрагдаж байсан хүүхэд